



Арьсны өвчин судлалын үндэсний төв

**АРЬСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДЛАХ
ЗӨВЛӨЛӨӨР ХЭЛЭЛЦЭН,
БАТЛАВ.**



**АРЬСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ
ТӨЛӨВЛӨГӨӨ
(2020-2024 ОН)**

2020 он

**ГАРЧИГ
ӨМНӨХ ҮГ**

НЭГ. УДИРТГАЛ

**ХОЁР. АРЬСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ТҮҮХЭН ТОВЧООН
ГУРАВ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ**

3.1. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ

- 3.1.1 АМБУЛАТОРИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ
- 3.1.2 НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ
- 3.1.3 ХЭВТҮҮЛЭН ЭМЧЛЭХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ
- 3.1.4 СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ
- 3.1.5. ЛАБОРАТОРИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ
- 3.1.6. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУЛГАМДСАН АСУУДАЛ

3.2. ХҮНИЙ НӨӨЦИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ

3.3. ЭРҮҮЛ МЭНДИЙН САНХҮҮЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ

3.4. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТЕХНОЛОГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ

3.5. ЭМ ЗҮЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ

**3.6. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, МЭДЭЭЛЛИЙН УДИРДЛАГЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ
ТУЛГАМДСАН АСУУДАЛ**

3.7. ТӨВИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ БА ИЛ ТОД БАЙДАЛ

ДӨРӨВ. ГАДААД ОРЧИН, ХАМТЫН АЖИЛЛАГАА

ТАВ. SWOT ШИНЖИЛГЭЭНИЙ МАТРИЦ

ЗУРГАА. БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ

6.1. АЛСЫН ХАРАА, ЭРХЭМЛЭХ ҮНЭТ ЗҮЙЛ, ЗАРЧИМ

6.2. СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ, ЗОРИЛГО, ЗОРИЛТ

ДОЛОО. ХҮРЭХ ҮР ДҮН

НАЙМ. ҮР НӨЛӨӨ

ЕС. САНХҮҮЖИЛТ

АРАВ. ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ БА НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ

АРВАН НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

АШИГЛАСАН ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧИГ, ХЭВЛЭЛИЙН ЖАГСААЛТ

ДҮРСЛЭЛ, ЗУРАГ:

- ДҮРСЛЭЛ 1. АМБУЛАТОРИЙН ҮЗЛЭГ (БОДИТ ТОО)
- ДҮРСЛЭЛ 2. АМБУЛАТОРИЙН ТЭРГҮҮЛЭХ 5 ӨВЧЛӨЛ
- ДҮРСЛЭЛ 3. ОРНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ДИНАМИК
- ДҮРСЛЭЛ 4. СТАЦИОНАРИЙН ӨВЧЛӨЛИЙН ТЭРГҮҮЛЭХ 5 ШАЛТГААН
- ДҮРСЛЭЛ 5. ЭМЧ, МЭРГЭЖИЛТНИЙ ХАНГАМЖ

ЗУРАГ 1. НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН УДИРДЛАГА, БҮТЭЦ
ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**ӨМНӨХ ҮГ**

Арьсны өвчин судлалын үндэсний төв нь арьс-харшлын өвчин, эмчилгээний гоо заслын чиглэлээр төрөлжсөн мэргэшлийн тусламж үйлчилгээг улсын хэмжээнд үзүүлж, эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил арга зүйгээр хангадаг лавлагаа шатлалын төв бөгөөд эрдэм шинжилгээ-судалгааны ажил эрхэлдэг, төгсөлтийн өмнөх болон дараах сургалт явуулдаг клиникийн түшиц эмнэлэг юм.

Бид дэлхий дахины арьс судлалын хөгжил дэвшил, Монгол Улсын эмнэлгийн тусламж, үйлчилгээний хөгжлийн бодлого, эрх зүйн орчны шинэчлэл, хүн амынхаа арьсны эрүүл мэндийн хэрэгцээ, шаардлагад үндэслэн, “Эрүүл арьс-Чанартай тусламж”- алсын хараанд нэгдэн, чинхүү сэтгэлээр ажиллаж

байна.

Манай байгууллага 2013 онд Олон улсын Чанарын Удирдлагын тогтолцооны ISO9001:2008, MNS.ISO 9001:2010 стандартыг салбартаа анхдагчаар нэвтрүүлж, 2018 онд амжилтаа бататган ISO9001:2015, MNS.ISO 9001:2016 стандартыг хэрэгжилтийг хангасан нь арьс-харшил, эмчилгээний гоо заслын тусламж, үйлчилгээний чанарын баталгаа, үр дүн юм.

2016 онд “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай” хууль, 2017 онд “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого” батлагдсанаар, эрүүл мэндийн салбарын ойрын ирээдүйн хөгжлийн чиглэлүүд тодорхойлогдон, төрийн өмчит эмнэлгүүд хагас бие даасан засаглалтай, ил тод нээлттэй хөгжих боломж бүрдлээ.

Мөн Монгол Улсын засгийн газар 2018 онд Дэлхийн тогтвортой хөгжлийн чиг хандлага, Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал-2030-д суурилан “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”-ыг баталж, “Хүн төвтэй нийгмийн бодлого”-ыг тэргүүлэх чиглэл болгох, хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулан, хүн амд эрүүл амьдрах зан үйлийг төлөвшүүлэх зорилтыг дэвшүүлсэн.

Бид энэхүү тэргүүлэх чиг хандлагатай уялдан, шинэ дэвшилтэд технологийг нэвтрүүлэн, арьс-харшил, эмчилгээний гоо заслын оношилгоо, эмчилгээг чанарын өндөр түвшинд хүргэхийг зорьж, 2020-2024 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөгөө боловсрууллаа.

Хөгжлийн стратеги нь 8 үндсэн чиглэлийн хүрээнд, олон улсын чиг хандлага, арьс-харшил, эмчилгээний гоо заслын шинэ эрэлт, хэрэгцээ, өнөөгийн нөхцөл байдал, тулгамдсан асуудалд үндэслэсэн үнэт баримт бичиг юм.

2020-2024 онд хэрэгжих стратеги нь АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй “Эмнэлгийн бие даасан байдлыг бэхжүүлэх” техник туслалцааны төслийн чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагаа, сургалтын үр дүн, төслийн зөвлөхүүдийн үнэтэй зөвлөгөөнд суурилан боловсруулагдсанаараа онцлог, ач холбогдолтой.

Хөгжлийн баримт бичиг нь бидний чиг хандлага, мэдлэг-ур чадвар, мэдрэмж, чанартай, үр дүнтэй, үр ашигтай гүйцэтгэл, бодит үнэлгээгээр хэрэгжиж, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж, үнэлэмжээр хэмжигдэх юм.

Стратегийг боловсруулсан ажлын хэсэг, тасаг нэгжийн удирдлагууд, хамт олон, санал, хүсэлт ирүүлсэн үйлчлүүлэгчид болон Эмнэлгийн бие даасан байдлыг бэхжүүлэх техник туслалцааны зөвлөх багынхандаа баярлалаа, гүн талархал илэрхийлье.

Хүн амын маань Арьс нь эрүүл -Сэтгэл нь тайван байг.,
Хамт олны минь өнөөдөр нь бүтэн-Ажил нь өөдрөг байхыг хүсье.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Ц.УРАНЧИМЭГ



СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН АЖЛЫН ХЭСЭГ



Ц.Уранчимэг, Ерөнхий захирал
Б.Батцэцэг, Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга
Ц.Сарангуа, Сургалт, эрдэм шинжилгээ эрхэлсэн захирал
Д.Батцэцэг, Чанарын албаны дарга
С.Уранчимэг, Хүний нөөцийн менежер
Д.Нансалмаа, Ерөнхий санхүүч
Г.Цогзол, Амбулаторийн тасгийн эрхлэгч
Ж.Энхжаргал, Лабораторийн тасгийн эрхлэгч
М.Амаржаргал, Эмчилгээний гоо засал, нөхөн сэргээх тасгийн эрхлэгч
Ө.Ариунаа, Сувилгааны албаны дарга
Э.Болорцэцэг, эм зүйн албаны дарга

НЭГ. УДИРТГАЛ

Арьсны өвчин судлалын үндэсний төв нь Улсын хэмжээнд арьс харшил, эмчилгээний гоо заслын чиглэлээр эмнэлгийн тусламж, үйлчилгээг амбулатори болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх, сургалт, судалгааны ажил эрхлэх, эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах чиг үүрэг бүхий лавлагаа шатны төрөлжсөн мэргэжлийн төв эмнэлэг юм.

АӨСҮТ нь ЭМЯ-ны бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, арьсны өвчнийг бууруулах бодлогыг тодорхойлох, боловсруулахад мэргэжил арга зүйн үндэслэлийг гаргаж, хамтран ажилладаг.

Үйл ажиллагааны үндсэн чиглэлийн хүрээнд арьс харшлын өвчнийг оношлох, эмчлэх, нөхөн сэргээх тусламж, үйлчилгээг зохион байгуулах, стандарт, удирдамж, аргачлал боловсруулах, төгсөлтийн дараах сургалт эрхлэх, олон нийтэд мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийх, олон улсын байгууллага, өндөр хөгжилтэй орнуудтай хамтран ажиллах зэрэг олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

Арьс-харшил, эмчилгээний гоо заслын чиглэлээр судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг хөгжүүлэх, нотолгоонд тулгуурласан шийдвэр гаргах зорилгоор 2003 оноос сургалт-эрдэм шинжилгээ эрхэлсэн албатай болж, улсын хэмжээнд арьсны өвчин судлалын чиглэлээр мэргэшүүлэх сургалт явуулан, олон улсын эрдэм шинжилгээний хурлуудыг зохион байгуулж байна. Мөн харшлын оношилгооны аллерген болон вакцин үйлдвэрлэж, тэдгээрийн нэр төрлийг олшруулан, технологийг илүү сайжруулахыг зорьж байна.

Дэлхий дахинд 85000 гаруй төрлийн химийн бодис үйлдвэрлэлд ашиглаж байгаагийн 2800 гаруй нь харшил үүсгэдэг болох нь тодорхойлогдон, эрдэмтэд 20 гаруй сая харшил төрүүлэгчийг судлан тогтоож, энэ нь цаашид огцом өсөх хандлагатайг сануулж байна.

Манай улсын хүн амын дунд орчны нөлөөт арьс харшлын өвчлөл тасралтгүй нэмэгдэж, өсөх хандлагатай байгаа нь статистикийн үзүүлэлтээр нотлогдож байна.

Хүн амын дундах ажилгүйдэл, ядуурал, эрүүл мэндийн боловсролын хангалтгүй байдал, эрүүл бус хооллолт, орчны бохирдол зэрэг олон сөрөг хүчин зүйлийн нөлөөлөл нь эрүүл ахуйн шалтгаант харшлын гаралтай арьсны эмгэгүүд ихсэхэд нөлөөлж, тулгамдсан асуудал болсоор байна.

Тухайлбал: 2018 онд ургамлын харшлын эмгэг 4680, хоол хүнсний харшлын эмгэг 3320 тохиолдол илэрсэн нь урд оноос өссөн үзүүлэлт юм.

Ойрын ирээдүйд хүн амын арьсны эрүүл мэндийн шинэ эрэлт хэрэгцээнд суурилан тусламж, үйлчилгээний хүрээг өргөтгөх, мэс заслын тусламж үйлчилгээг нэвтрүүлэх, хөдөө орон нутгийн эмч, мэргэжилтний арьс-харшлын өвчний оношилгоо, эмчилгээний мэдлэг, ур чадварыг түлхүү хөгжүүлэх хэрэгцээ, шаардлага өндөр байна.

Энэхүү хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн, арьс харшил, эмчилгээний гоо заслын тусламж, үйлчилгээнд дэвшилтэд технологи, инновацыг нэвтрүүлэх, тусламж, үйлчилгээг чанартай, шуурхай, хүртээмжтэй хүргэх, үйлчилгээний соёлын сэтгэл ханамжийг тасралтгүй дээшлүүлэх нь манай байгууллагын гол чиг шугам болж байна.

Бид байгууллагынхаа өнөөгийн нөхцөл байдал, тулгамдсан асуудал, сүүлийн 5 жилийн статистикийн тоон үзүүлэлтэд тулгуурлан дүн шинжилгээ хийж, энэхүү стратегийг боловсруулав. Дүн шинжилгээ хийхдээ асуудлын дүн шинжилгээний арга болон статистикийн дүн шинжилгээний аргуудыг ашиглан, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа, гомдол, санал хүсэлтийг судлан, стратегийн зорилго, зорилтоо тодорхойлон үйл ажиллагаагаа төлөвлөв.

ХОЁР. АРЬСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ТҮҮХЭН ТОВЧООН

Төв нь Арьс өнгөний алба байгуулагдсаны 94 жил, Арьсны өвчин судлалын Үндэсний төв байгуулагдсаны 74 жилийн түүхэн замналтай, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонт байгууллага юм.

- 1926-1946 он** **Арьс өнгөний өвчнийг эмчлэх анхны тасаг байгуулагдав.**
1926 онд Улсын клиникийн төв эмнэлэгт арьс өнгөний өвчнийг эмчлэх анхны тасаг нээгдэв.
1930 онд 18 аймгийн төвийн больницуудад хэвтүүлэн эмчлэх ор ажиллуулж эхлэв.
- 1946-1976 он** **Арьс өнгөний өвчнийг эмчлэх нэгдсэн диспансер байгуулагдав.**
1946 онд 150 ортой арьс өнгөний нэгдсэн диспансер болон өргөжив. Энэ үед нэгдсэн диспансер больницыг Зөвлөлт Оросын эмч Т.И.Наружный удирдаж байв.
1962 онд Улсын арьс өнгөний диспансерын бүрэлдэхүүнээс гаргаж, Улаанбаатар хотын Эрүүлийг хамгаалах газрын харьяанд шилжүүлэн, Арьс-Өнгөний больниц нэртэйгээр орны тоог 250 болгон өргөтгөсөн байна.
1964 онд арьсны халдварт мөөгөнцөрт өвчнүүдийг эмчлэх тасаг шинээр нээгдэж, улмаар төрөлжсөн мэргэжлийн кабинетуудтай болов.
1965 онд Патогистологийн лаборатори байгуулагдав.
1972 онд Улаанбаатар хотын АДХ-ын Гүйцэтгэх захиргаа, нийтийн аж ахуй үйлчилгээний газрын харьяанд байсан “Эмчилгээний гоо заслын үйлчилгээний тасаг”-ыг нэгтгэснээр эмчилгээний гоо заслын суурь тавигдсан.
- 1977-1993 он** **Арьс өнгөний эмгэг судлалын нэгдсэн төв болов.**
1977 онд Арьс өнгөний өвчнийг эсэргүүцэх Улсын диспансерыг Улаанбаатар хотын арьс өнгөний нэгдсэн диспансертай нэгтгэснээр “Арьс өнгөний эмгэг судлалын нэгдсэн төв” болж, үндэсний хэмжээнд үйл ажиллагаа өргөжив.
- 1994-2011 он** **Арьсны өвчин судлалын төв байгуулагдав.**
1994 онд Арьсны өвчин судлалын төв болж, үйл ажиллагааны чиглэл шинэчлэгдэж, өнгөний тасгийг Эрүүл мэндийн сайд, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн тушаалаар Халдвартын клиникийн эмнэлэгт хүний нөөц, ор, тоног төхөөрөмжийн хамт нэгтгэв.
2004 онд Нөхөн сэргээх тасгаа өргөтгөн, Хэнтий аймгийн Дэлгэрхаан суманд Аварга тосон сувиллыг 50 ортой нээв. Мөн онд Харшил судлалын лаборатори нээгдэв.
- 2012-2018 он** **Арьсны Өвчин Судлалын Үндэсний Төв болов.**
2012 онд Арьсны Өвчин Судлалын Үндэсний Төв болж, сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр үйл ажиллагаагаа өргөжүүлэв.
2013 онд Чанарын Удирдлагын тогтолцооны ISO9001:2008, MNS.ISO 9001:2010 стандартыг эрүүл мэндийн салбартаа анхдагчаар нэвтрүүлэв. 2018 онд ISO9001:2015 олон улсын стандартыг хэрэгжүүлэгч байгууллага болж, ололтоо бататгав.

2013 онд Сэтгэл нийцсэн 8 үйлчилгээг Улсын хэмжээнд нэвтрүүлсэн Монгол Улсын загвар эмнэлэг болов.

2016 онд **Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор** шагнуулсан нь хамт олны 90 жилийн нөр их хөдөлмөрийн үнэлэмж юм.

2019 онд Шадар сайдын нэрэмжит “Чанарын Үндэсний шагнал”-аар үйлчилгээний чиглэлээр эрүүл мэндийн салбараас анх удаа авсан.


ГУРАВ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ

3.1. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ

3.1.1. Амбулаторийн тусламж, үйлчилгээ: Амбулатори нь 11 их эмч, 3 сувилагч, 7 асрагчтай, нийт 27 ажилтантайгаар арьс, арьсны харшлын өвчнийг оношлох, эмчлэх, урьдчилан сэргийлэх тусламж үйлчилгээг улсын хэмжээнд үзүүлдэг.

Сүүлийн 5 жилийн дунджаар авч үзвэл амбулаторийн үзлэгийг жилд дунджаар 83312 хүнд, урьдчилан сэргийлэх үзлэгийг 11163 хүнд, идэвхтэй хяналтыг 688 хүнд хийж байна. Хөдөө орон нутгийн үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдэж, дунджаар 14274 хүн үзүүлж байгаа нь нийт үзлэгийн 15.0%-ийг эзэлж байна.

ДҮРСЛЭЛ 1. АМБУЛАТОРИЙН ҮЗЛЭГ (БОДИТ ТОО)




Бодит тоон үзүүлэлтээс харахад сүүлийн 3 жилд үзлэгийн тоо тасралтгүй нэмэгдэж, 2015 оныг суурь он болгон 2019 онтой харьцуулбал, нийт үзлэгийн тоо 1.3 дахин ихэссэн нь арьс харшлын өвчлөлийг тоо болон амбулаторийн ачаалал тасралтгүй нэмэгдэж байгааг харуулж байна. Үзлэгийн тоо нэмэгдсэн ч арьс, харшлын эмчийн тоо нэмэгдээгүй байна.

Урьдчилан сэргийлэх үзлэгийг 2015 онтой харьцуулахад сүүлийн 5 жилийн дундаж 1.2 дахин нэмэгдсэн нь арьс харшлын тусламж, үйлчилгээний хүртээмж сайжирсантай холбоотой юм. 2019 оны хувьд амбулаторийн үзлэг урд онуудаас нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Харин идэвхтэй хяналтыг 2015 онтой харьцуулахад 2.2 дахин буурсан, бодит индекс тогтворгүй байгаа нь энэ үйл ажиллагаанд анхаарал хандуулах, аймаг, дүүргийн арьсны кабинетын эмч нартай хамтран ажиллах, өрхийн болон гэрийн сувилгаа, эргэлтийн үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.

ДҮРСЛЭЛ 2. АМБУЛАТОРИЙН ТЭРГҮҮЛЭХ 5 ӨВЧЛӨЛ (БОДИТ ТОО)



Амбулаторийн өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаанаас харахад, сүүлийн 5 жилд харшлын шалтгаантай арьсны үрэвсэлт өвчнүүд тасралтгүй тэргүүн байранд, дунджаар амбулаторийн нийт үзлэгийн 15.6%-ийг эзэлж байгаа нь энэ өвчнөөс урьдчилан сэргийлэх олон талт, хамтын үйл ажиллагааг өргөжүүлэх хэрэгтэйг нотолж байна.

Арьс-харшлын оношилгоо, шинжилгээгээр ургамлын харшлын эмгэг 2019 оны байдлаар 5351, хоол хүнсний харшлын эмгэг 2195 оношлогдсон нь урд оноос өссөн үзүүлэлт юм.

2019 онд харшлын аллергин эмчилгээнд урд оноос 2 дахин (442) хүн, аутосеровакцин эмчилгээнд урд оноос 7 дахин (171) хүн нэмэгдсэн, плазмаферез эмчилгээг 130 удаа хийсэн нь хэдийгээр нэг талаас эмч, мэргэжилтний ачаалал нэмэгдсэн боловч, нөгөө талаас байгууллагын өөрийн орлогыг нэмэгдүүлсэн үр дүн юм.

Сүүлийн жилүүдэд харшлын шалтгаанд өвчлөл нэмэгдэхийн хэрээр харшлын аллерген эмчилгээнд хамрагдах хүний тоо нэмэгдэж байгаа нь энэ үйлчилгээг өргөжүүлэх, мөн өдрийн эмчилгээний хүрээг өргөтгөх шаардлагатайг харуулж байна.

2019 оны байдлаар амбулаторийн эмч нарын ачааллыг гаргаж үзэхэд 1 их эмч дунджаар жилдээ 8613 хүн үзэж, хамгийн олон нь 9588 үзсэн нь ачаалал ихтэйг нотолж байна.

Амбулаторийн 1 их эмч өдөрт 45 хүн үзэхээр тооцоолон, цахим бүртгэлээр дугаар олгож, илүү гарсан тохиолдолд буцаадаг нь нэг талаар хүлээгдэл тооцох боломжгүй, нөгөө талаас үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжид сөргөөр нөлөөлж байгааг анхаарах шаардлагатай. Гэхдээ өдөрт 45 хүн үзнэ гэдэг нь бусад эмнэлэгтэй харьцуулахад 15-20 хүнээр илүү тооцоолол юм.

Яаралтай тусламжийн тасаггүй, хүний нөөц болон тоног төхөөрөмж, бусад нөөцүүд хангалтгүй нь тусламж, үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжид сөргөөр нөлөөлж байна. Зориулалтын бус байртайгаас зарим үзлэгийн өрөө болон үйлчлүүлэгчдийн өрөөнүүдэд крантгүй, 00 тоо дутмаг, эмнэлгийн байрны урсгал буруу зэрэг нь халдвар хамгаалал эрүүл ахуйн дэглэм алдагдахад хүргэж байна.

Цаашид амбулаторийн тусламж, үйлчилгээний ажлын байрны дүн шинжилгээ хийж, ажлын ачааллыг зөв тодорхойлох, үүрэг, даалгаврын хуваарийг тэнцвэржүүлэх, амбулаторийн тусламж, үйлчилгээний нэр төрлийг олшруулан, эмчээ нээлттэй сонгон үйлчлүүлэх үзлэгийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Мөн амбулаторид зохион байгуулалт, бүтцийн өөрчлөлт хийх, тасгуудыг стандартад нийцүүлэн засварлах, эмчилгээний нэр төрлийг (арьсны мэс ажилбар, гоо сайхны

эмчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, хөлийн арьсны эмгэгүүдийн үед хийгдэх эмчилгээ) нэмэгдүүлэн, хүний нөөц, тоног төхөөрөмжөөр хангах нь чухал байна.


3.1.2. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ: Төв нь нийгмийн эрүүл мэндийн орон тооны ажилтантай. Тасаг, нэгжүүдийн сувилагч, эмчилгээний хоол зүйчтэй хамтран нийгмийн эрүүл мэндийн болон арьс-харшлын өвчний чиглэлээр хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох, мэдээлэл, сургалт, сурталчилгааг байгууллагын веб, фэйсбүүк хуудас, телевиз, дотоод сүлжээг ашиглан цахим хэлбэрээр болон хэвлэмэл байдлаар хийж, эрүүл мэндийн зөвлөгөө өгдөг.

Мөн нийтийн эзэмшлийн хүлээлгийн хэсгүүдэд нийгмийн эрүүл мэндийн мэдээлэл сурталчилгааны дуугүй хөтөч, лавлагаа, зөвлөгөө, өгөх үйл ажиллагаа, сургалт зохион байгуулдаг. Төрөлжсөн мэргэшлийн эмч нар ихэвчлэн олон нийтийн мэдээллийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр тухайн цаг үеийн өвчлөлтэй уялдсан мэдээлэл, сурталчилгаа хийдэг.


Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтын ажиллагаа хангалтгүй, санхүүжилт зохицуулагдаагүй, нийгмийн эрүүл мэндийг тэргүүлэх чиглэл болгох хандлага төлөвшөөгүй, судалгаа, нотолгоо муутай, хүн амын боловсрол хангалтгүй, сургалт, сурталчилгаа хийх тоног төхөөрөмж, нөөц хангалтгүй зэрэг тулгамдсан асуудлууд тулгарч байна. Цаашид эмнэлгийн маркетинг, мэдээлэл, сургалт, сурталчилгааны хэвлэлийн нэгж, тоног төхөөрөмжтэй болох шаардлагатай.

3.1.3. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ: Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээг 8 их эмч, 24 сувилагч, 4 тасаг, 170 ортойгоор үзүүлж байна. 2015-2019 оны 5 жилийн дунджаар, жилд 5534 өвчтөнийг хэвтүүлэн эмчилсэн ба 2015 оныг суурь он болгон авч үзэхэд хэвтэн эмчлүүлэгчийн тоо 1.12 дахин нэмэгдсэн байна.

ДҮРСЛЭЛ 3. ХЭВТСЭН ӨВЧТӨН, ДУНДАЖ ОР ХОНОГИЙН ДИНАМИК




ДҮРСЛЭЛ 4. ОРНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ДИНАМИК



2019 оны байдлаар фонд ашиглалт 88.7%, дундаж ор хоног 8.7, орны эргэлт 30.1 байна. Орны хүлээгдэл 2014 онд 0-3 хоног байсан бол сүүлийн жилүүдэд хүлээгдэл үүсээгүй нь тусламж, үйлчилгээний шуурхай байдлын давуу тал юм.

ДҮРСЛЭЛ 5. СТАЦИОНАРЫН ӨВЧЛӨЛИЙН ТЭРГҮҮЛЭХ 5 ШАЛТГААН



Сүүлийн 5 жилийн стационарын өвчлөлийн тэргүүлэх шалтгаанаас гүвдрүүт хайрст өвчин тасралтгүй нэгдүгээр байранд орж байна. Гэхдээ 2015 онтой харьцуулахад 152 тохиолдлоор нэмэгдсэн, хэлбэлзэл бага.

Харин хулжмал арьстас өвчин, гүвдрүүт хайрст өвчнөөс 2 дахин бага боловч, жил тутам тасралтгүй нэмэгдэж, 2015 онтой харьцуулахад 196 тохиолдлоор буюу 0.7 дахин нэмэгдсэн нь энэ чиглэлийн тусламж, үйлчилгээг өргөжүүлэх шаардлагатайг харуулж байна.

Эмнэлгийн нас баралт сүүлийн 5 жилд 3 тохиолдол бүртгэгдсэн байна. Үндсэн оношны зөрөөг сүүлийн хоёр жилээр харьцуулан авч үзэхэд 0.10% байна. Эрчимт эмчилгээнд жилдээ дунджаар 30 орчим хүн эмчлүүлдэг ба хүндрэл гаргалгүй ажилласан нь үйл ажиллагааны давуу тал юм. Хөдөө, орон нутгаас 5 жилийн дунджаар 940 орчим хүн жилд хэвтэн эмчлүүлсэн ба хэвтэн эмчлүүлэх нь жил бүр нэмэгдэх хандлагатай ч орны хүлээгдэлгүй байна.

Эмчилгээний гоо заслын үзлэгийг сүүлийн 5 жилийн дунджаар 9657 хүнд хийж байна. 2019 онд үзлэгийн тоо харьцангуй нэмэгдэж, 10309 болсон нь сүүлийн 5 жилийн хамгийн өндөр индекс юм.

Гэхдээ төдийлөн тогтвортой нэмэгдээгүй нь хувийн хэвшлийн, өрсөлдөгч арьс харшил, эмчилгээний гоо заслын эмнэлгүүд олширсон, мөн гоо заслын үйлчилгээнд олон шинэ технологийг нэвтрүүлэн үйлчлүүлэгчийг татах болсонтой хамааралтай байх магадлал өндөр юм.

Харин эмчилгээний гоо заслын эмчилгээ жил тутам нэмэгдэж, нийт үзүүлсэн хүний 70.0% нь гоо заслын эмчилгээнд хамрагдаж байгаа нь давуу тал юм. Гэхдээ эмчилгээний гоо заслын жижиг мэс засал хийхгүй байна. Цаашид энэ чиглэлийн технологийг түлхүү нэвтрүүлэх нь өрсөлдөгчдөд үйлчлүүлэгчээ алдахгүй байх нэг боломж юм.

Эмийн бус нөхөн сэргээх эмчилгээ сүүлийн жилүүдэд өсөж, тасралтгүй өсөж, 5 жилийн дунджаар 5000 орчим хүнд хийсэн байна 2019 оныг 2014 онтой харьцуулахад 2.17 дахин нэмэгдсэн нь энэ тусламж, үйлчилгээ нилээдгүй шаардлагатайг харуулж, бодлогоор дэмжих, тоног төхөөрөмж, нөөцийг нэмэгдүүлэх хэрэгтэйг нотолж байна.

Хүүхдийн тасгийн дундаж ор хоног 5-7, орны эргэлт хурдан, хүүхдийн өвчний түүхийн оношны үндэслэлийг 2 удаа бичдэг зэрэг нь ачааллыг ихэсгэж, хүүхдийн эмч,

сувилагчийн хүрэлцээ хангалтгүй байна. Дүрс оношилгоо хангалтгүй, сүүлийн 3 жилд огт хийгдэхгүй байгаа нь анхаарал татаж байна. Харин дотрын эмчийн үзлэг эрс нэмэгдэж, 2018 онд 2014 оноос 4.6 дахин өсч, зүрхний цахилгаан бичлэгийн тоо мөн үзлэгээ даган нэмэгдсэн нь ачаалал их байгааг харуулж байна.

Цаашид клиникийн тасаг амбулаторийн уялдааг сайжруулан, амбулаторийн кабинетуудыг төрөлжүүлэн зохион байгуулах (мөөгөнцөр, хүүхэд, харшил гэх мэт), эмнэл зүйн удирдамжууд боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангах шаардлагатай. Мөн яаралтай тусламжийн тасагтай болох, эрчимт эмчилгээний эмчгүй байгаа нь эрхтэн системийн талаас хүндрэл гарсан үед бэрхшээл тулгарч байгааг анхаарах хэрэгтэй байна.

3.1.4. Сувилахуйн тусламж, үйлчилгээ: Сувилахуйн алба нь бага эмч 2, сувилагч 29, лаборант 8, эм найруулагч 2, ариутгагч 2 гэсэн бүрэлдэхүүнээр сувилахуйн тусламж үйлчилгээг үзүүлдэг. Тасаг нэгжүүд нь арьс, гоо заслын төрөлжсөн мэргэшлийн сувилагчтай, хөрвөн ажиллах чадвар сайтай.

Шинээр ажилд орсон сувилагч, эмнэлгийн мэргэжилтнийг чиглүүлэн сургах хөтөлбөр, гарын авлагатай, дагалдуулан ажлын байранд сургах үйл ажиллагаа тогтмолжсон. Хөдөө орон нутгийн сувилагч нарыг мэргэжил арга зүйгээр ханган ажилладаг.

Сувилагчийн орон тоо дутмаг, стандартын дагуу эмч сувилагчийн харьцаа 1:2-д хүргэх боломж бага, цалингийн төсөв хүрэлцээгүй. Орон тооны дутагдал нь сувилахуйн тусламжийг хүн бүрт хүргэхэд сөргөөр нөлөөлдөг.

Цаашид яаралтай тусламж, эрчимт эмчилгээний чиглэлээр сувилагч сургах, арьсны өвчний үед үзүүлэх хэсэг газрын эмчилгээ, сувилгааны зааврыг батлуулж, хэрэгжилтийг хангах, орон нутгийг арьсны мэргэшсэн сувилагчтай болгох талаар санал боловсруулан, холбогдох газар хүргүүлэх зэрэг асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай.

3.1.5. Лабораторийн тусламж, үйлчилгээ: Лабораторийн тасаг нь 15 хүний бүрэлдэхүүнтэй. Лабораторийн тасаг нь клиник биохими, иммунологи серологи, бактерологи мөөгөнцөр, гистологи иммуногистохимийн лабораториудтай. Лабораториуд нь Япон Улсын Sysmex, Olympus, Герман Улсын Leica, АНУ-ын X-rida, STAT FAX брэндийн сүүлийн үеийн тоног төхөөрөмж ашиглан, хүлээгдэлгүй ажилладаг давуу талтай.

Гематологи, биохими, микробиологи, патогистологи гэсэн 4 чиглэлээр, 13 нэр төрлийн шинжилгээг, 5 жилийн дунджаар 43768 хүнд хийсэн ба шинжилгээний тоо жил тутам нэмэгдсээр байна. Тухайлбал: 2014 онд нийт 40295 байсан бол 2019 онд 57863 болж, даруй 17568-аар нэмэгдсэн нь ачаалал нэмэгдэж байгааг харуулах үзүүлэлт юм.

Шинжилгээний 18.5%-ийг гематологийн, 17.4%-ийг биохимийн, 14.3%-ийг эмнэлзүйн бактерлогийн, 13.7%-ийг шээсний, 12.6%-ийг серологийн, 10.1%-ийг иммунохимийн, 9.5%-ийг мөөгөнцөрийн, 2.2%-ийг демодексийн, 1.1%-ийг амьд эд эсийн, 0.6% нь эсийн, эрүүл зүйн бактерологи, иммуногистохимийн шинжилгээнүүд эзэлж байна.

Лабораторийн чанарын гадаад үнэлгээнд тогтмол хамрагдаж сайн үнэлгээ авдаг. Тухайлбал: Арьсны эдийн шинжилгээ авч оношийн баталгаажилт хийх үйл ажиллагаа тогтмолжсон нь гадаад хяналт сайжирсан давуу тал юм.

хүнээс арьсны эдийн шинжилгээ авч, 95%-д оношийн баталгаажилт хийж, дүгнэлт гаргасан ба 3.6% орчим нь ховор тохиолдох эмгэгүүд эзэлж байна. Ховор тохиолдох

эмгэгүүдийг dermatology mosaic, иммунофлюоресценц, иммуногистохимийн шинжилгээ хийж оношилдог.

2019 онд цэцгийн тоосноос үүдэлтэй харшил ялган оношлох өвөрмөц стандарт аллерген бэлтгэж, хот хөдөөгийн харшил судлалын кабинетуудад нийлүүлсэн. Мөн шарилжийн цэцгийн тоосноос үүдэлтэй харшлаас сэргийлэх цацлага аллергин вакцин хийж байна.

Лабораторийн тоног төхөөрөмж, харьцангуй шинэчлэгдэн автоматчилагдаж, 2019 онд автоклав, термостат, хатаах шүүгээгээр хангагдсан. Лабораторийн урвалж, оношлуур худалдан авах төсөв бага тул бүрэн хүчин чадлаараа ажиллахад хүндрэл учирдаг.

Лабораторийн био аюулгүй байдал, хүний нөөцийн тогтвор суурьшил, гадаад оронд сургалтад хамруулах үйл ажиллагаа хангалтгүй. Тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтэл гарахад гэрээт газраас инженер дуудаж цаг алддаг, мөн IT инженер, тоног төхөөрөмжийн инженерүүдийн хамтын ажиллагаа хангалтгүй зэрэг нь тусламж, үйлчилгээнд сөргөөр нөлөөлж байна.

Үйл ажиллагааны өргөжилтийг хангахын тулд иммунологийн бүрэн автомат төхөөрөмж, бүлэгнэлтийн аппарат, гематологийн бүрэн автомат анализатор, гистологийн автомат будагч нэн тэргүүнд шаардлагатай байна.

3.1.6.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тулгамдсан асуудал

Арьсны зарим өвчнөөс сэргийлэх, эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээ авах өнөөгийн тогтолцоо сул байна. Харшлын гаралтай арьсны үрэвсэлт өвчний талаарх хүн амын эрүүл мэндийн боловсрол хангалтгүй, өвчнөө архаг хэлбэрт шилжсэний дараа эмнэлэгт ханддагаас эмнэлгийн тусламж үйлчилгээ, эдийн засагт хүндрэл учруулж байна.

2018 оны байдлаар арьс харшлын өвчлөл Монгол улсад тэргүүлэх 10 өвчлөл дотор 10000 хүн амд 546 тохиолдол бүртгэгдэж 6 байранд орж байна.

Аймаг, дүүргийн арьс-харшлын кабинеттай хамтран үйлчлүүлэгчдэд зориулсан арьс-харшлын өвчний эрүүл мэндийн сургалтуудыг үе шаттай, үр дүнтэй зохион байгуулах үйл ажиллагаа хангалтгүй байна.

Эмчилгээний гоо заслын мэс ажилбар, мэс заслын тусламж, үйлчилгээ явуулахад шаардлагатай нөөц, тоног төхөөрөмж, мэдлэг ур чадвар хангалтгүй байна.

Эмчилгээний гоо засал, сэргээн засах тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээ нэмэгдэхийн хэрээр орчин үеийн дэвшилтэд технологийг нэвтрүүлэх үйл ажиллагаа дутагдаж байна.

Хүүхдийн тасгийн хэвтүүлэн эмчлэх өрөө нь стандартын шаардлага хангадаггүй, өрөөний агааржуулалт хангалтгүй, хүүхдүүд сахиурын хамт 1 оронд хэвтэж агаарын солилцоог муутгадаг, зэрэг тулгамдсан асуудал тулгарч байна.


Хүүхдийн арьс харшлын тусламж, үйлчилгээнд зөөврийн рентген аппарат, зөөврийн хүчилтөрөгчийн аппарат, хүүхдийн монитор, хүүхдийн насанд тохирсон даралтын аппарат, хүүхдийн ор шаардлагатай байна.

Сувилахуйн дадлага сургалтыг шинэлэг арга хэлбэрээр явуулах, анхан шатны маягтын хөтлөлтийг цахимжуулах, дотоод сүлжээнд холбох үйл ажиллагаа хангалтгүй байна. Түүнчлэн цахилгаан шатгүй, тасаг нэгжүүдийн эд аж ахуйн хэрэгсэл хангалтгүй, төсвийн хүрэлцээ дутмаг байна.

3.2. ХҮНИЙ НӨӨЦИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ

АӨСҮТ нь хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлдэг ба биелэлт 95%-тай байна. Өнөөгийн байдлаар АӨСҮТ-ийн батлагдсан орон тоо 140, ажиллаж буй орон тоо 143 байна.

2019 онд 36 их эмч, 43 сувилагч, тусгай мэргэжилтэн, бусад ажилтан 73 ажиллаж байна. Эмнэлгийн мэргэжилтний 80.5%-ийг 30-50 насны хөдөлмөрийн насныхан эзэлж, эмнэлгийн ажиллах хүчин залуужиж байна. 2019 онд сонгон шалгаруулалтаар 25 ажилтан шинээр ажилд орж, 25 ажилтан чөлөөлөгдсөн нь шилжилт хөдөлгөөн ихтэй байгааг харуулж байна. Гэрээт ажилтан 6 байна. Эмч сувилагчийн харьцаа 1:1.1 байна.



Ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулан, ажлын байрны тодорхойлолтыг нь танилцуулан гарын үсэг зуруулснаар ажил үүргийн хуваарь болон хариуцлагыг баталгаажуулдаг. Ажлын байрны үүрэг, даалгаврын хяналтыг тасгийн эрхлэгч, ахлах сувилагч нар хариуцдаг, захиргааны багаас 7 хоног бүр хяналт тавьдаг.

АӨСҮТ-д шинжлэх ухааны доктор 1, анагаах ухааны доктор 1, клиникийн профессор 7, анагаах ухааны магистр 20, бакалавр зэрэгтэй сувилагч 3 ажиллаж, докторант, магистрантад 12 хүн суралцаж, дотоодын сургалтад тогтмол 95%-иас дээш хамрагдаж, их эмчийн 70.8%, сувилагч, эмнэлгийн мэргэжилтний 36.4% нь мэргэжлийн зэрэг, цолтой байгаа нь хүний нөөцийн давуу тал юм.

2017-2019 оны байдлаар 8 хүн төрийн одон медалиар, 12 хүн эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан, 18 хүн ЭМЯ-ны жуух бичиг, 3 хүн бусад шагналаар шагнагдсан нь манай хамт олны хөдөлмөрийг салбараас үнэлсэн үнэлгээ юм.

Суралцагч байгууллага байх, дэвшилтэд технологийн нэвтрэлтийг хангах зорилгоор 2003 оноос сургалт-эрдэм шинжилгээ эрхэлсэн ажлын алба байгуулагдаж, арьс судлалын мэргэшил олгох, дээшлүүлэх, эмчилгээний гоо заслын эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх, байгууллагынхаа эмч, мэргэжилтний чадавхыг тасралтгүй дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Резидентийн болон богино хугацааны багц цагийн сургалт явуулахдаа шавилан сургах арга хэлбэрийг ашиглах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, гадаад дотоодын ижил төст эмнэлэгтэй гэрээ байгуулан ажиллах, олон улсын эмч, мэргэжилтэнтэй хамтарсан ажлын байрны сургалт зохион байгуулах, судалгаа хийх, эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах зэрэг олон талт үйл ажиллагааг зохион байгуулдаг.

2019 оны байдлаар арьс судлал, гоо заслын чиглэлээр 13 эмч, мэргэжилтнийг сургаж, төрөлжсөн мэргэшил эзэмшүүлсэн ба жилд дунджаар 10-12 мэргэжилтэн бэлтгэн төгсгөж байна.

ДҮРСЛЭЛ 5. ЭМЧ, МЭРГЭЖИЛТНИЙ ХАНГАМЖ

Эмч, сувилагчийн тоо сүүлийн 5 жилд онц өөрчлөлтгүй, их эмчийн тоо 33-аас 36 болж өссөн, сувилагч 31-32, эмч эмнэлгийн мэргэжилтэн 13-14 хүн ажиллаж байна.

“Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа, MNS 6330:2017 стандартын дагуу 1 эмчид наад зах нь 2 сувилагч ногдоно гэвэл сувилагчийн хэрэгцээ их байна.

Эмч, мэргэжилтний чадавхыг тасралтгүй дээшлүүлж, зөвхөн 2018 онд БНСУ, Австри, Япон, БНХАУ-д мэргэжил дээшлүүлэх сургалтад 8 эмч хамрагдаж, АШУҮИС-ийн арьс судлалын мэргэжил дээшлүүлэх сургалтад 4 их эмч, өөрийн төвийн мэргэшил эзэмшүүлэх сургалтыг 6 сувилагч суралцан төгссөн.

Төрөлжсөн мэргэшил олгох, дээшлүүлэх сургалтад хамрагдсан ажилчдынхаа, ажлын цагийн зохицуулалт хийж, цалинтай чөлөө олгодог.

2017-2019 онд АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй “Эмнэлгийн бие даасан байдлыг бэхжүүлэх” төсөлд удирдлагын баг бүрэн хамрагдаж, чанар, хүний нөөц, гүйцэтгэл, үйл явц, санхүүгийн удирдлагын чиглэлээр мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн нь нэг давуу тал юм.

Эмнэлэг нь дотоод сүлжээ, 24 цагийн интернэтэд бүрэн холбогдож, эмч мэргэжилтэн онлайнаар зайн сургалтад хамрагдах, зайн сургалт зохион байгуулах, хүн амд арьс харшлын өвчний мэдээ, мэдээлэл, сурталчилгааг цаг алдалгүй хүргэж байна.

Ажилтны цалин хөлс, урамшууллыг нэмэгдүүлэх арга хэмжээг жил бүр зохион байгуулдаг. Тухайлбал: 2019 онд улирлын үр дүнгийн урамшуулалт цалинд 224,5 сая₮, жилийн эцсийн урамшуулалд 92,9 сая₮, мэргэшлийн зэргийн нэмэгдэлд 35,8 сая₮, ур чадварын нэмэгдэлд 130,5 сая₮, илүү цагийн хөлсөнд 241,3 сая төгрөг тус тус олгосон.

Мөн онд үйл ажиллагааны давсан орлого 30,0 сая₮-ийг ажилтнуудын нийгмийн халамж, байгууллагын тоног төхөөрөмжийг шинэчлэхэд зориулан зарцуулсан, гэр хороололд амьдардаг ажилчиддаа түлээ нүүрний үнийн хөнгөлөлт 29,6 сая төгрөг, орон сууцны зээлтэй ажилнууддаа 22,2 сая төгрөгний дэмжлэг тусламж үзүүлж, өдрийн хоолыг хөнгөлттэй үнээр, оройн ээлжийн бүх ажилтанд үнэгүй хоол олгох зэрэг нийгэм халамжийн тэгш, хүртээмжтэй олон талт арга хэмжээг нээлттэй авч хэрэгжүүлсэн.

2018 онд “Ажилтнуудад ур чадвар олгох” журмыг шинэчлэн боловсруулж, тулгамдсан асуудал, санал хүсэлтийг сонсон, 96%-ийг нь шийдвэрлэх арга хэмжээ авч, дэмжлэгт удирдлагаар хангасан.

2019 онд ЗГ-ын тогтоолоор төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн шатлал нэмэгдэж, нийт цалин 8-11 хувиар, ажилчдын унаа, хоолны мөнгө өдрийн 5000 төгрөгөөр тооцогдон нь урд оноос 50,000 төгрөгөөр нэмэгдсэн.

Эмч, ажилтанд урьдчилан сэргийлэх оношилгоо, үзлэг хийж, шаардлагатай тохиолдолд дархлаажуулалтад хамруулдаг. Шинээр ажилд орж байгаа эмч, ажилтнуудыг ажилд орохоос нь өмнө В,С вирусийн шинжилгээнд хамруулдаг.

Мөн эмч, ажилчдын хувцсыг мэргэжлийн ангиллаар жигдрүүлсэн нь байгууллагын хүрээнд цалин, нэмэгдэл урамшуулал, нийгмийн халамжийн үйлчилгээг адил тэгш авдаг, байгууллагын дэмжлэгт удирдлага сайн байна.

Хүний нөөцийн тулгамдсан асуудал:

Шаардлагатай зарим орон тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна. Тухайлбал ЭМЯ-ны 1:2 хөтөлбөрийн дагуу сувилагч нарын орон тоог нэмэгдүүлэх, чанарын менежер, дотоод аудитын ажилтан, эдийн засагч, эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, сэтгэл зүйч, нийгмийн эрүүл мэндийн ажилтан, бохир материал хариуцсан ариутгагч, хуулийн зөвлөх зэрэг орон тоо нэн шаардлагатай байна.

Хүний нөөцийн ажлын байрны дүн шинжилгээ хийж, ажлын байрны тодорхойлолтыг нарийвчлан боловсруулахад ашиглах, гүйцэтгэл, үүрэг даалгаврын хэрэгжилтийг зөв арга хэрэгслээр үнэлэх үйл ажиллагаа дутмаг.

Дэвшилтэд технологийн нэвтрэлттэй уялдан эмч, мэргэжилтнийг багаар сургах, хэрэглэгчдийн шинэ эрэлт хэрэгцээнд нийцсэн төрөлжсөн мэргэшлийн мэргэжилтэн (эмчилгээний гоо заслын мэс засалч, хүүхдийн арьс, мөөгөнцөр, арьсны хавдар, харшлын эмч, эрчимт эмчилгээний эмч, мэргэжилтэн, гистологиийн эмч) хангалтгүй.

Мэргэжлийн зэрэг хамгаалалт жил бүр нэмэгдэж, төрөлжсөн мэргэшлийн сургалтад тасралтгүй хамрагдаж байгаа ч ижил төстэй хувийн хэвшлийн арьс харшил, эмчилгээний гоо заслын эмнэлэгтэй өрсөлдөх чадвар төдийлөн хангалтгүй. Мэргэшлийн ур чадварыг үнэлдэг тогтолцоо сул, арга хэрэгсэл тодорхой бус.

Мэргэшсэн хүний нөөц нь мэдлэг, ур чадвараа үйл ажиллагаандаа ашиглах идэвх санаачилга сул, нотолгоонд тулгуурласан шийдвэр гаргах, эрдэм судлал, судалгаа шинжилгээ хийх чадавх дутмаг.

Мөн ачааллыг тэнцвэржүүлэн, тасаг нэгжийн бүтэц, орон тоо, гүйцэтгэл-үр дүнгээр цалинжуулах, хагас бие даасан засаглалыг хангах санхүүгийн тогтолцоо, боломж одоогоор бүрдээгүй.

Үйлчлүүлэгчдээс ирж буй санал, гомдлын дийлэнх нь эмч, мэргэжилтний ёс зүй, харилцаа, хандлага, үйлчилгээний соёлтой холбоотой, энэ нь байгууллагын нэр хүндэд сөргөөр нөлөөлдөг.

Эмч, ажилтны дийлэнх нь цалингийн болон бусад хэлбэрийн зээлтэй, өөрийн орон сууцгүй амьдарч байгаа нь тэдэнд чиглэсэн нийгэм-халамжийн тусламж, үйлчилгээг улам өргөжүүлэх шаардлагатайг харуулж байна.

3.3. САНХҮҮЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Санхүүжилтийг 2019 оны байдлаар авч үзэхэд нийт 3 тэрбум 373,1 сая (3,373,079,594 төгрөг) төсвийн 84,7% нь эрүүл мэндийн даатгал, 4% нь улсын төсөв, 11% нь үндсэн үйл ажиллагааны орлого, 0.3% нь туслах үйл ажиллагааны орлогоос орохоор төсөвлөгдсөн.

Төсвийн зүйл ангиар авч үзвэл 71,5% нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлд, 16,8% нь эмийн зардалд, 3,3% нь тогтмол зардалд, 5,8% нь хоолны зардалд, 2,6% нь бусад зардалд зарцуулагдсан.

2019 оны байдлаар тогтмол зардлаас 18,5 сая.төгрөг хэмнэсэн. Хэмнэгдсэн зардлыг дийлэнхийг багаж, хэрэгсэл худалдан авах, урсгал засвар хийх, хог хаягдал, тавилга авах зэрэгт зарцуулсан бол давсан орлогын зарцуулалт нь ажилчдын нийгмийн баталгааг хангахад зарцуулж ажилласан.

2019 оны байдлаар 38,5 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 15,6 сая төгрөгийн тавилга эд хогшил авч хөрөнгө оруулалт хийсэн.

Нэмэгдсэн хөрөнгө нь лабораторийн, сэргээн засах, хоол үйлдвэрлэлийн болон үйлчлүүлэгчдийн тав тухыг хангахад чиглэсэн тоног төхөөрөмж, тавилга эд хэрэгсэл байна.

Санхүүгийн ил тод байдлыг хангаж, байгууллагын веб сайт болон Сангийн яамны shilendans.gov.mn сайтад санхүүгийн мэдээ мэдээллийг тогтмол байршуулдаг.

Нийт санхүүжилтийнхээ 85.8%-ийг эрүүл мэндийн даатгалын сангаас авч буй тохиолдолд баярын амралтын өдрүүд ихтэй тохиолдолд гүйцэтгэл төсөвтөө хүрэхгүй өртэй гарах үе тохиолддог.

Өвчнийг оношийн бүлгээр санхүүжүүлдэг боловч өртгийн тооцоо сүүлийн жилүүдэд шинэчлэгдээгүй учраас үзүүлж буй тусламж үйлчилгээний өртөг бодит байдалтай нийцэхгүй байгаа нь төсөвт нөлөөлж байна. Мөн төрөөс санхүүжилт арьсны хавдар (C84) болон арьсаар илэрдэг тууралтат халдварт өвчин (B00-B08) оношийн бүлгүүдэд тусламж үйлчилгээний санхүүжилт авч чадахгүй байна.

Мөн тасгийн эрхлэгч, эмч, мэргэжилтний санхүүгийн мэдлэг хангалтгүй, эдийн засгийн үр ашгийн тооцоо хийх, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх хандлага, санаачилга дутмаг, инновацийг дэмжих нөөц хангалтгүй байна. Урьдчилан сэргийлэх үзлэгийг албан байгууллагуудтай гэрээ хийж, төлбөртэй хийх арга замыг эрэлхийлэх нь чухал байна.

Цаашид эдийн засгийн дүн шинжилгээ хийдэг арга барилд шилжин, оношийн бүлэгт тулгуурлан, өртөг зардлыг тооцож, үр дүнгүй оношилгоо, эмчилгээний судалгаа хийж, тусламж, үйлчилгээний оновчтой, үр дүнтэй, үр ашигтай байдлыг хангаж ажиллах шаардлагатай.

3.4.ЭРҮҮЛ МЭНДИЙН ТЕХНОЛОГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Чанарын алба нь орон тооны 1, орон тооны бус 6 гишүүнтэй. Алба нь эмнэлгийн тусламж, үйлчилгээний технологийн хэрэгжилтэд хяналт тавин, дотоод аудит, эрсдэлийн төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг хангаж, үл тохирлуудыг засан, зөвлөх, дэмжин туслах чиглэлээр ажилладаг.

Төв нь Чанарын удирдлагын тогтолцооны олон улсын (ISO9001:2008, ISO9001:2010MNS, ISO9001:2015, ISO9001:2016MNS) стандартыг салбартаа анхдагчаар амжилттай хэрэгжүүлсэн нь тусламж, үйлчилгээний чанарын баталгаа юм.

Тусламж, үйлчилгээний чанарын нэг үзүүлэлт болох өвчний намжмал хугацаа нэмэгдэж байна. Тухайлбал: Арьсны архаг, удаан хугацааны нөхөн сэргээх эмчилгээ шаарддаг арьс цайх, цэврүүтэх өвчин, хавтгай улаан үлд, мөөгөн хэлбэрийн микоз өвчний намжмал үеийн дундаж хугацаа 1-3 сар уртсаж байгаа нь тусламж, үйлчилгээний чанар сайжирч буйг харуулсан үзүүлэлт юм.

Цаашид энэ хугацааг тогтворжуулахад эмчийн ур чадвар, эмчилгээний чанар, өвчтөний хувийн идэвхтэй үйл ажиллагаанаас шууд хамраалтай байгааг анхаарч ажиллах шаардлагатай.

Үүний тулд сэргээн засах тусламж, үйлчилгээ болон Аварга тосон сувиллын үйл ажиллагааг өргөжүүлэх нь чухал юм. Аварга тосон сувиллын нөхөн сэргээх эмчилгээг дунджаар 300 орчим хүнд хийдэг ба намжмал үеийн хугацааг уртасгаж, арьсны архаг дахилтат өвчнүүдийн нөхөн сэргээх эмчилгээний үр дүн, чанарыг сайжруулахад зохих үр дүнгээ өгдөг.

Чанарын тасралтгүй байдлыг хангахдаа хяналтын хуудас, шалгууруудыг ашигладаг. Тухайлбал: “Клиникийн тасгуудын ажил дүгнэх шалгуур үзүүлэлт”, “Амбулаторийн тасгийн ажил дүгнэх шалгуур үзүүлэлт”, “Лабораторийн тасгийн ажилчдын ажил дүгнэх шалгуур үзүүлэлт”, “Гал тогооны ажилчдын ажил дүгнэх шалгуур” үзүүлэлт ашигладаг.

Мөн эмчилгээ, оношилгооны түгээмэл үйлдлийн стандартын хэрэгжилтийг жил бүр үнэлдэг. 2019 онд өвчний түүхийн хяналтаар 22 төрлийн 80 гаруй алдаа зөрчил, амбулаторийн картын стандартын бичилтийн хяналтаар 11 төрлийн 30 гаруй алдаа зөрчил илэрч, эмийн жор бичилтийн стандартын мөрдөлт 89.8% байгаа нь энэ чиглэлээр тодорхой арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагатайг харуулсан.

Эмнэлгийн үйлчилгээтэй холбоотой халдвар, нас баралт гараагүй, мөн хэвтүүлэн эмчилсэн, шилжүүлсний дараа 1 сарын дараах нас барсан тохиолдол байхгүй байгаа тусламж, үйлчилгээний чанарын баталгаа юм.

Төв нь сүүлийн жилүүдэд дараах дэвшилтэд технологиудыг нэвтрүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Арьсны гэмтэлтэй хавсран явагдаж болзошгүй аутоиммун өвчнүүдийн ялгах оношилгоонд бөөмийн 12 төрлийн эсрэг бие илрүүлэх евростандарт шинжилгээ хийх.,
- Арьсны хурц болон архаг хордлогын үед цус цэвэршүүлэн шүүх плазмаферез эмчилгээг, PCS 2 “Heamonetics” автомат аппаратаар хийх.,
- Хумсны мөөгөнцөрт өвчний үед Podolognova аппарат ашиглах.,
- КОН 10% уусмалаар бага насны хүүхдүүдийн халдварт нялаахай өвчнийг үр дүнтэй, зовуургүй эмчлэх
- 17% салицилийн спиртийн уусмалаар улны үү болон хүүхдийн олон тооны үүг эмчлэх.,
- Харшлын аллерген эмчилгээнд шахмал хэлбэрээр антиполиныг нэвтрүүлэх.,
- Мөөгөнцөрт өвчний оношилгоонд флюоресцент микроскопоор Калькофлюор вайт ашиглан оношлох.,
- Судас гэрэлтүүлэх улаан гэрэл ашиглан нярай хүүхдийн судас хатгах.,
- Хайрст үлд өвчний эмчилгээнд метотрексатыг нэвтрүүлэх.,
- Бепантен, Мометокс тосон түрхлэг нэвтрүүлэх.,
- Харшил судлалын лабораторид аллерген бэлтгэн ургамлын тоосны харшлын эмчилгээ хийх.,
- Хөлдөөх, үс түүх, гэдэс цэвэрлэх, усан, лазер эмчилгээнүүд.,
- Арьсны хэв шинж, чийгшилт, тослог тодорхойлох, хөгшрөлт үнэлэх.,
- Ботокс, гиалуроны хүчил, цасан цагаан тарилгууд.,
- Келойд сорвины эмчилгээ, тууралтан доторх тарилга эмчилгээ.,
- Мэдрэлийн гаралтай өвдөлт бүхий эмгэгүүдэд TENS аппаратыг ашиглах.,
- Нарийн зурваст хэт ягаан В туяаны эмчилгээ хийх.,
- Арьсны Аутоиммун өвчнийг тодорхойлох АНА шинжилгээг хийх.,
- Шалтгаан тодорхойгүй чонон хөрвөс өвчний үед Анти C1Kү эстераза хийх.,
- Эмчилгээний гоо заслын PRP эмчилгээ буюу ялтаст эсээр баяжуулсан сийвэнгээр тарих эмчилгээ
- Арьс цайх өвчнийг эмчлэх “EXIMER” лазер зэрэг дэвшилтэд технологиудыг тус тус нэвтрүүлээд байна.

Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгаагаар эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлыг 82.9% нь сайн гэж үнэлсэн ба 17.0% нь сэтгэл ханамжгүй байгааг анхаарах шаардлагатай.

Мөн үйлчлүүлэгчдийн 14.0% нь эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёл, байгууллагын соёлд сэтгэл ханамжгүй байна.

2019 оны байдлаар Засгийн газрын 11:11-д ирсэн 10 санал-гомдол, 1 талархал ирүүлсэн. Гомдлын дийлэнх нь эмч, эмнэлгийн мэргэжилтний харилцаа, ёс зүйтэй холбоотой.

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний технологийн тулгамдсан асуудал:

Эмнэл зүйн тусламж, үйлчилгээний стандарт, удирдамжийн хэрэгжилт хангалтгүй, хяналт үнэлгээг эмч, мэргэжилтнүүд шалгалт гэж хүлээж авдаг сэтгэлгээ хэвээр, эерэг хандлага дутмаг. Эмч, мэргэжилтнүүдийн эмнэл зүйн стандарт, удирдамжийн талаарх мэдлэг хангалтгүй, хяналтын хуудсаар үнэлүүлэх арга барилд суралцаагүй.

Тусламж, үйлчилгээний аюулгүй байдал, эрсдэлийн үнэлгээ үр дүн багатай. Ойрын жилүүдэд үйл ажиллагаандаа нэвтрүүлэх шаардлагатай эмчилгээний гоо заслын хүний нөөц, мэс ажилбар, мэс заслын иж бүрдэл, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл хангалтгүй.

Төр хувийн хэвшлийн түншлэл, гадаад харилцаа, хандив тусламжийн үйл ажиллагаа дутмаг байна. Цаашид бүх эмч нарыг гоо заслын жижиг мэс ажилбаруудыг хийх, үс, меланоцит эсийг шилжүүлэн суулгах ажилбарыг эх орондоо нутагшуулах, эмчилгээний гоо заслын жижиг мэс ажилбар хийх зэрэг технологиудыг шинээр нэвтрүүлэх шаардлагатай.

3.5. ЭМ ЗҮЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Эм зүйн алба нь 6 хүний бүрэлдэхүүнтэй. Эм зүйн тасаг нь эмийн санд тавигдах нийтлэг шаардлага MNS 5376:2014 стандартыг мөрдлөгө болгон ажиллаж, эмнэлгийн чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслээр тасралтгүй, жигд хүртээмжтэй хангах ажлыг зохион байгуулах, клиник эм зүйн тусламж, үйлчилгээг хурдан шуурхай үзүүлж, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх сургалт сурталчилгааны ажил зохион байгуулах, эмийн гаж нөлөө бүртгэх, тэдгээрийг үнэлэх, эмийн тайлан, мэдээг гаргах, эм найруулан бэлтгэх чиг үүргийг хүлээдэг.

Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендерийг жил бүр төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, эм, эмнэлгийн хэрэгсэл, лабораторийн урвалж бодисоор нэгдсэн журмаар хангадаг. Байгууллагын хэмжээнд 330-аад нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл, 180-аад нэр төрлийн лабораторийн урвалж бодис нийлүүлж, сар бүр дотоод хяналт тавьдаг.

Түүнчлэн эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх, нийлүүлэлтийн хуваарийн дагуу эм эмнэлгийн хэрэгслийг татан авах, хуваарийн дагуу нийлүүлээгүй албан байгууллагуудад хяналт тавих, эмийн түүхий эд чанарын шаардлага хангаагүй тохиолдолд мэргэжлийн хяналтын лабораторид шинжилгээнд явуулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлдэг.

Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендерийг жил бүр зохион байгуулж, эм, эмнэлгийн хэрэгслээр нэгдсэн журмаар хангадаг. Байгууллагын хэмжээнд 300 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн нийлүүлж, сар бүр дотоод хяналт тавьдаг.

Эм зүйн тусламж, үйлчилгээний тулгамдсан асуудал:

Эм зүйчийн орон тоо бага. Стандартаар 40 оронд 1 эм зүйч байх ёстой. Манайд 80 оронд 1 эм зүйч ноогдож байна. Эм зүйчийн ажлын байрны тодорхойлолтын дагуу үүрэгт ажлаа хийхэд хүндрэлтэй, ачаалал ихтэй учир эм тараах, өвчний түүхийн эмийн бодолтыг хийх зэрэг ажлыг хийдэг учир үндсэн клиник эм зүйн тусламж үзүүлэхэд хүндрэлтэй.

Эмнэлгийн эмийн нөөцийг зөв тодорхойлох, эмийн захиалга, хэрэглээг хэрэгцээнд үндэслэн тооцох цахим программ хангамж, мэдээний нэгдсэн сангуй.

Дотоод бэлдмэлийг хугацаандаа хэрэглэхгүй хугацаа хэтрүүлэх, үлдэгдэл ихтэй атлаа захиалга нэмж өгөх, сахиургүй хүүхдүүдэд эмийг нь цагт нь уулгахгүй байх, хүлээн авахад эмийн хадгалалтын хугацаа дууссан байхад солихгүй байх, хэрэглэсэн эмийн бүртгэл хөтлөхгүй (А шүүгээний) байх зэрэг дутагдлууд гарч байгаад анхаарах, цаашид хяналтын хуудсыг тасаг нэгжүүд үйл ажиллагаандаа нэвтрүүлэх шаардлагатай.

Эмийн төсөв хангалтгүйгээс, багц доторх чанар муутай, хямд үнэтэйг эмүүд сонгож байгаа нь эмчилгээний чанарт сөргөөр нөлөөлж, тулгамдсан асуудал болж байна. Цаашид эмийн сан, эм ханган нийлүүлэх байгууллагатай цахим программ хангамжаар холбогдох, тасаг нэгж руу эмийн захиалга, олголт, зарлагыг бар кодтой болгох, цахимжуулах, битүүмж сайтай хадгалалтын хэрэгсэл, тавилгаар хангах хэрэгтэй байна.

Мөн шинэ эмийн бэлдмэлүүдийг оруулж эмнэл зүйд нэвтрүүлэх (биологийн бай эмүүд, цитостатик, ретиноидууд, ДДС, миноксидил, 5 редуктаза үс ургалтад нөлөөлдөг эмүүд болон хүүхдийн тусламж, үйлчилгээнд изотретинойн)-ийг улсын бүртгэлд бүртгүүлж, тендерт оруулах, хүүхдэд цусаар үздэг харшлын сорилуудыг даатгалд оруулах шаардлагатай байна.

3.6. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, МЭДЭЭЛЛИЙН УДИРДЛАГЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Төв нь дотоод сүлжээнд бүрэн холбогдсон, дотуур холбооны 10 цэгтэй, интернет холболт ашиглан, эмчилгээ үйлчилгээний мэдээллийн нээлттэй, шуурхай байдлыг хангаж байна. Төв нь цахим хэлбэрээр албан бичиг явуулах, хүлээн авахдаа Able (<https://intranet.gov.mn/index.php>) албан бичгийн программыг ашигладаг.

Телемедицин, зайн оношилгоо, эмчилгээ, цахим сургалт, эмнэл зүй эмгэг анатомийн конференцийг үндэсний хэмжээнд зохион байгуулдаг. 2019 онд цахим бүртгэл мэдээллийн ажлын байрны дүн шинжилгээ хийж, үйлчилгээний шуурхай байдлыг хангах зорилгоор цахим бүртгэлийн 1 ажилтан нэмж ажиллуулсан.

Цахим бүртгэлийн 2 суурин утас ажиллуулан, өдөрт дунджаар 50-80 хүнд үйлчлэн, тусламж, үйлчилгээ авах дугаар урьдчилан өгдөг болсон нь зохих үр дүнгээ өгч байна.

Мөн Skype-р холбогдож түргэн шуурхай мэдээлэл дамжуулан 103-тай холбогдох нөхцөл бүрдсэн. Цахимаар, хүлээн авах нэгжээс, эмчилгээний тасаг руу өвчний түүх бүртгэгддэг. Үйлчлүүлэгч хүсвэл цахим хаяг мэйлээр шинжилгээний хариуг илгээдэг.

Үйлчлүүлэгчийн бүртгэл, үйлчлүүлэх дарааллыг ил тод болгох зорилгоор амбулаторийн үзлэгийн өрөөнүүдийн үүдэнд 11 дэлгэц суурилуулж тогтмол ажиллагаанд оруулснаар үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж дээшилсэн.

Тасгуудын үүдэнд лед дэлгэц байршуулан нийгмийн эрүүл мэнд, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр болон арьсны зонхилон тохиолдох эмгэгүүдийн эмчилгээ, урьдчилан сэргийлэх зөвлөмж, мэдээллийг 24 цагаар тогтмол явуулдаг.

Эрчимт эмчилгээний тасгийн үүдэнд ар гэрийнхэнтэй нь харилцах боломжтой дэлгэц байрлуулсан, өвчтөний тухай товч мэдээлэл, амин үзүүлэлтийг мэдээлдэг.

Эмнэлгийн давхруудад тасаг тус бүр 2, нийт 16 дуугүй камертай. Төв нь Хас зангилаа ХХК, Ай Мед Техноложис ХХК-тай гэрээ байгуулсан, эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ хийлгэж байна.

Лабораторийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг Пролианс ХХК хариуцан ажилладаг.

Ажилчдын цаг бүртгэл цахим хэлбэрт бүрэн шилжиж, цагийг хурууны хээгээр бүртгэн, ажилтан бүрийг сар бүр цагийн баланс гарган хянадаг.


Телемедицин, зайн оношилгоо, эмчилгээ, сургалтын тоо, үр дүнг дээшлүүлэх, өндөр хөгжилтэй орны туршлагаас зайнаас суралцах, эрдэм шинжилгээний хуралд зайнаас оролцох, онлайн номын сан ашиглах зэрэгт шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг шуурхай цаг алдалгүй хийх нь нэн тэргүүний тулгамдсан асуудал юм.

Б байрны интернэт дотоод сүлжээний хурд удаан, хяналтын сүлжээний төхөөрөмжүүд хуучирч, байнга гацдаг, мөн шаардлагатай программ хангамжууд (антивирусны, эмийн сангийн программ) дутагдалтай байна.

Цаашид хяналтын камерын системийг өргөтгөх, тоог нэмэгдүүлэх, байгууллагын веб хуудасны үйл ажиллагаа, хөгжүүлэлтийн тасралтгүй байдлыг хангахын тулд хүний нөөцөөр хангах, цахим эрүүл мэнд төслийн хүрээнд хэрэгжиж буй e.health програмыг бүрэн нэвтрүүлэх, сүлжээний болон бусад (VPN төхөөрөмж, файрвол, шилэн кабель) тоног төхөөрөмжөөр хангагдах шаардлагатай.

3.7. ТӨВИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ БА ИЛ ТОД БАЙДАЛ

Төвийн ерөнхий захирлаар удирдуулсан захиргааны зөвлөл нь 7 хүний бүрэлдэхүүнтэй. Зөвлөл нь хамтын зарчмаар шийдвэр гаргаж, үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, үйл ажиллагааг удирдан чиглүүлдэг. Эмийн эмчилгээг зохицуулах хороо, цус цусан бүтээгдэхүүнийг зохицуулах зөвлөл, ёс зүйн хороотой. Хагас бие даасан эмнэлгийн засаглалын тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжилтийг хангах зорилтоор 2019 оны 10 сард 9 хүний бүрэлдэхүүнтэй Төлөөлөн удирдах зөвлөл, 2020 оны 01 сард ТУЗ-ын даргыг сонгож, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батламжлагдсан.

ЗУРАГ 1. ТӨВИЙН УДИРДЛАГА, БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

АӨСҮТ нь Сургалт эрдэм шинжилгээний алба, чанарын алба, сувилахуйн алба, эм зүйн алба, мэдээлэл технологийн албатай. Стационарын 4 тасаг, лабораторийн тасаг, зөвлөх поликлиник, лаборатори, эмчилгээний гоо засал, нөхөн сэргээх тасаг, захиргаа, санхүү аж ахуйн тасаг, хоол үйлдвэрлэлийн тасагтай. Аварга тосон дахь харьяа сувилалтай.

Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангахад чиглэсэн цахим хуудастай, үйл ажиллагааны болон санхүүгийн мэдээ, мэдээллийг нээлттэй байршуулдаг. Байгууллагын соёл, орчны тав тух, эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа, тусламж, үйлчилгээний тэгш байдал, хүлээгдлийн талаар үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа тогтмол авч, дүн шинжилгээ хийж, үр дүнг ил тод мэдээлэн, чанар сайжруулах хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгадаг.

Сэтгэлд шингэсэн 8 үйлчилгээгээр улсын загвар эмнэлэг болж, “Эрүүл мэндийн байгууллагын үйлчилгээний соёл”, “Яг цагтаа”, “Шинэ санаа- Шилдэг арга туршлага” зэрэг олон талт өдөрлөг аян зохион байгуулж байгаа нь үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн үзүүлэлтийн тогтвортой байдалд эергээр нөлөөлж байна.

АӨСҮТ-ийн барилга нь 37 гаруй жилийн өмнө баригдсан, Нийт 20000 м² талбайтай. стандартын бус, цэргийн казармын зориулалтай, тоосго ба бетон материалаар баригдсан 4 давхар барилгатай. Сантехникийн шугам сүлжээ муудсан их засвар хийх зайлшгүй шаардлагатай. Төвийн үндсэн хөрөнгө, ялангуяа тавилга эд хогшил аппарат багаж хэрэгсэл ерөнхийдөө муудаж, эмнэлэг үйлчилгээний өнөөгийн шаардлага хангахгүй дийлэнх шинэчлэх шаардлагатай байна.

Эмнэлгийн гадаад орчны тохижилтыг хангах, ялангуяа хэвтэн эмчлүүлэгчид агаарт гарах боломж нөхцөл муу, машины зогсоолын тохижилт хангалтгүй зэрэг нь үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжид сөргөөр нөлөөлдөг. Цаашид хагас бие даасан засаглалыг үр дүнтэй хэрэгжүүлэх, хүний нөөц, санхүүгийн шийдвэрийг байгууллагын онцлогтой уялдуулан бие даан зохицуулах, хүн амын арьсны эрүүл мэндийн шинэ эрэлт хэрэгцээнд үндэслэн, тусламж, үйлчилгээ, зохион байгуулалт, бүтцийг оновчтой зохион байгуулах шаардлагатай.

ДӨРӨВ. ГАДААД ОРЧИН, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Гадаадын 10 гаруй оронтой хамтран ажиллах гэрээтэй ажилладаг. Тухайлбал: Солонгос Улсын Kangbuk Samsung эмнэлэг, ОХУ-ын Эрхүү, Улан-Үдэ, Москва хот, Австри Улсын KA, Rudolfstung hospital, Дани Улсын Roskilde hospital, Япон Улсын Hokkaido University, Япон Улсын Aiiiku hospital, Сингапур Улсын Арьсны төв, АНУ-ын Арьсны академи, БНХАУ-ын Тайваны Medical Union зэрэг олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Байгууллагын нийт эмч нарын 90% нь хөгжингүй оронд мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан нь гадаад хамтын ажиллагааны боломж юм. Тухайлбал: 2018 онд Тайвань улсын “Tri-Service General Hospital”, Цэргийн төв эмнэлэг болон Юанг-Пунг сүлжээ эмнэлэгтэй хамтын ажиллагааны гэрээ, ОХУ-ын РУДН их сургуульд харшил судлалын чиглэлээр эмч суралцуулах гэрээ байгуулж, Япон улсын КюүШү эмнэлэгтэй холбоо тогтоогоод байна.

Япон улсын Жайка байгууллагын төслийн хүрээнд 7 сургагч багш бэлтгэгдсэн. Member of American Монголын Арьс Өнгөний Эмч нарын нийгэмлэгтэй хамтран 2 жил тутамд бага хурал, 4 жил тутамд их хурал, мөн Арьс Судлаачдын Монголын нийгэмлэгтэй хамтран хавар, намрын чуулганыг тогтмол зохион байгуулдаг.

АШУҮИС, ЭМХТ, ЦССҮТ, "Хан жи Од" ХХК, “Элемент” ХХК-тай хамтын ажлын гэрээтэй. Цаашид гадаад хамтын ажиллагаа, гадаадын хөрөнгө оруулалт, тусламжийг оновчтой ашиглах, төр хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагааг өргөжүүлэх нь чухал байна. АӨСҮТ нь хотын хойд хэсэгт, Сүхбаатар дүүргийн нэгдсэн эмнэлэг, Иргэний бүртгэл мэдээллийн төв, барилгын материалын том захын дэргэд байршдаг.

Энэ нь зам тээврийн олон сөрөг эрсдэлт хүчинг дагуулдаг. Мөн гэр хороололд ойрхон оршдог нь агаарын болон хөрсний бохирдол, тоос шороо ихтэй орчныг бүрдүүлж, эмнэлгийн гадаад орчны тав тухгүй байдлыг үүсгэдэг. Хөдөө, орон нутгаас ирж үйлчлүүлж буй үйлчлүүлэгчдийн нэлээдгүй хувь нь өвчнөө хүндрүүлж ирдэг нь байгууллагын эдийн засагт ихээхэн сөрөг үр дагавартай.

Бодлогын түвшинд эрх зүйн олон баримт бичиг шинэчлэгдэж байгаа боловч, санхүүжилт шийдэгдээгүй нь нийтлэг бэрхшээл болж байна. Тухайлбал, стандартаар орон тоог нэмэх шаардлагатай ч санхүүгийн боломж байхгүй байна. Арьс харшил, эмчилгээний гоо заслын хувийн хэвшлийн эмнэлгүүдийн тоо сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэж, зарим нь эмнэлгийн тусламж, үйлчилгээний наад захын шаардлага хангаагүй, ялангуяа эмчилгээний гоо заслыг мэргэшлийн бус түвшинд үзүүлж байна.

Хувийн хэвшлийн эмнэлгээр үйлчлүүлээд өвчнөө хүндрүүлсэн, сэтгэл санааны дарамтад орсон үедээ АӨСҮТ-д ханддаг, хариуцлага тооцох тогтолцоо хангалтгүй байгаа нь бэрхшээл учруулж байна. ЭМЯ, мэргэжлийн хяналтын байгууллагын нэгдсэн зохицуулалт, хяналт сул байна.

Эм, эмнэлгийн хэрэгсэл бэлтгэн нийлүүлэгч байгууллага болон төсвийн хөрөнгөөр нийлүүлэх бараа, ажил үйлчилгээний гүйцэтгэгч, нийлүүлэгчийг сонгон шалгаруулах журмын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажилладаг. Цаашид харилцагч талтай цаашдаа хүрээгээ өргөсгөн, чанартай бүтээгдэхүүнийг зах зээлийн бөөний үнээр авах шаардлагатай байна.

Улс төрийн бодлогын нөлөөллөөс хамааран байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, бүтцийн өөрчлөлт хийгддэг нь хөгжилд тодорхой хэмжээгээр саад учруулдаг.

Мөн зах зээлийн үнийн өсөлт нь эмчилгээний тоног төхөөрөмж, эм, урвалжийн үнэд тасралтгүй нөлөөлдөг, ялангуяа эмийн зах зээлийн хяналт сул, үнийн өсөлт өндөр байгаа нь эдийн засгийн хямралд оруулдаг нь нэг тулгамдсан асуудал, гадаад орчны бэрхшээл болж байна.

ТАВ. SWOT ШИНЖИЛГЭЭНИЙ МАТРИЦ

ДОТООД ОРЧИН	
ДАВУУ ТАЛ (STRENGTHS)	СУЛ ТАЛ(WEAKNESSES)
- Байгууллагын алсын хараа, зорилго тодорхой, үйл ажиллагааны чиглэл тодорхой, байгууллагын соёл төлөвшсөн. - Олон улсын чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлж, батламж авсан. - Байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтний 95.0% нь төрөлжсөн мэргэшлээр мэргэшсэн, 65.0% мэргэшлийн зэрэгтэй. - Хүний нөөцийн хөгжил, хувь хүний карьерийн хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлдэг. - Цалин, урамшууллыг хуулийн дагуу олгож, нээлттэй ил тод байдлыг хангаж ажилладаг - Эрдмийн зөвлөлтэй, олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулдаг туршлагатай - Санхүүгийн өр авлагагүй ажилладаг, санхүүгийн аудитын үнэлгээгээр тогтмол сайн үнэлэгддэг. - Барилгыг өргөтгөл шинээр баригдсан - Цахим бүртгэл мэдээлэл, цахим эмнэлэг болох үйл ажиллагаа хэрэгждэг. - Эм, эмнэлгийн хэрэгсэл, лабаоатрийн урвалж бодисын хангалт сайн - Орны хүлээгдэлгүй ажилладаг - Телемедицин, зайн сургалт, оношилгоо, эмчилгээ хийдэг, интернет сүлжээнд бүрэн холбогдсон. - Шинэ технологи, тоног төхөөрөмж дээр багаар ажиллах чадавхыг бүрдүүлдэг	- Төлөвлөлт, гүйцэтгэл, үйл явцын уялдаа сул - Ажилтны шилжилт хөдөлгөөн ихтэй - Эмч, сувилагчийн харьцаа олон улсын жишигт хүрээгүй, батлагдсан орон тоогоор хүний нөөцөө бүрдүүлэх боломжгүй - Эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх төсөв хүрэлцээгүй, хариуцсан орон тооны ажилтангүй, судалгааны чадавх хангалтгүй - Эмнэлгийн зориулалтын байргүй - Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангамж, засвар үйлчилгээ хангалтгүй - Автомашин зогсоолын тохижилт хийгдээгүй, тав тухгүй - Цахим сүлжээ, зайн сургалтын тоног төхөөрөмж хүрэлцээ хангалтгүй жилийн төсөв бодит хэрэгцээнд хүрдэггүй - Зарим төрөлжсөн мэргэшлийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн (гистологич, физик эмчилгээний эмч, эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, г.м) дутагдалтай. - Гамшиг тохиолдсон үед ажиллах баг, нөөцийн хангамж байхгүй
ГАДААД ОРЧИН	
БОЛОМЖ (OPPORTUNITIES)	БЭРХШЭЭЛ (THREATS)
- ЭМЯ-харьяа байгууллага, шууд удирдлагаар хангагддаг. Бодлого, эрх зүйн орчны шинэчлэл, үйл ажиллагааны чиглэл удирдлагыг шууд авдаг. - Эмнэлэг нь цахилгаан, дулааны сүлжээнд холбогдсон, халуун хүйтэн устай. - Интернэтийн орчин бүрдсэн. - Ижил төстэй тусламж, үйлчилгээ үзүүлж буй өрсөлдөгч байгууллага олноор бий болсон нь хөгжлөөс суралцах, зарим талаар хамтран ажиллах боломжтой - Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах үйл ажиллагааны тендерийг зохион байгуулдаг - Гадаадын 10 гаруй оронтой хамтын ажиллагаатай.	- ЭМД-аас дийлэнх санхүүжилтээ авч буй тохиолдолд үйлчлүүлэгчээ хувийн хэвшлийн эмнэлэгт алдах, санхүүгийн эрсдэлд орох магадлалтай - Барилгын худалдааны том захын дэргэд байрладаг, байнга түгжрэлтэй - Гэр хороололд ойрхон, агаарын бохирдол ихтэй, тоосжилт, утаатай орчинтой - Тендерийн багцаар чанаргүй, хямд эм, эмнэлгийн хэрэгсэл сонгогддог. - Эмч, эмнэлгийн мэргэжилтний арьсны өвчний талаарх мэдлэг, ур чадвар хангалтгүй. Гоо заслын мэргэшүүлэх сургалтад хамрагдах боломж бага. - Арьсны зарим төрөлжсөн мэргэшлийн ур чадварыг Монгол Улсад сургах сургалтын тогтолцоо, хөтөлбөр байхгүй. - Хүн амын арьсны эрүүл мэндийн талаарх мэдлэг, хандлага хангалтгүй

ЗУРГАА. БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ

6.1. АЛСЫН ХАРАА, ЭРХЭМЛЭХ ҮНЭТ ЗҮЙЛ, ЭРХЭМЛЭХ ЗАРЧИМ

АЛСЫН ХАРАА:

ЭРҮҮЛ АРЬС-ЧАНАРТАЙ ТУСЛАМЖ

ЭРХЭМ ЗОРИЛГО:

ОЛОН УЛСЫН ТҮВШИНД ХҮРСЭН АРЬС-ХАРШИЛ, ЭМЧИЛГЭЭНИЙ ГОО ЗАСЛЫН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛЭХ

ОЛОН УЛСЫН ТҮВШИНД ХҮРСЭН АРЬС-ХАРШИЛ, ЭМЧИЛГЭЭНИЙ ГОО ЗАСЛЫН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЧАНАРТАЙ, АЮУЛГҮЙ, ШУУРХАЙ ҮЗҮҮЛЭХ

ЭРХЭМЛЭХ ҮНЭТ ЗҮЙЛС:

- Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж-Бидний итгэл, найдвар
- Үйлчлүүлэгчийн арьсны эрүүл мэнд- Бидний чанарын баталгаа
- Үйлчлүүлэгчийн эдгэрэлт –Бидний дэвшил, хөгжил
- Үйлчлүүлэгчийн инээмсэглэл-Бидний ёс зүй, хариуцлага

БИДНИЙ ЭРХЭМЛЭХ ЗАРЧИМ

- Зөв хандлага, хүндлэлд суурилсан соёлтой
- Үйл явц нь хэрэгцээнд суурилсан, оновчтой
- Гүйцэтгэл нь үр дүнтэй, үр ашигтай
- Тусламж, үйлчилгээ нь аюулгүй, чанартай
- Хүний нөөц чадварлаг, мэдрэмжтэй
- Хагас бие даасан тогтолцоотой

БИДНИЙ ӨДӨР ТУТАМ МӨРДӨХ ДҮРЭМ:

- Алсын хараа, эрхэм зорилгоо дээдлэнэ.
- Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангаж ажиллана.
- Арьс харшил, эмчилгээний гоо заслын эрэлт хэрэгцээнд тулгуурлана.
- Тасралтгүй суралцагч байгууллага байж, Үндэсний хэмжээний арьс харшил, гоо заслын эмч, мэргэжилтэнг чанартай бэлтгэнэ.
- Тусламж, үйлчилгээ нь шинэ санаа, шинэ мэдлэг, дэвшилтэт технологи, нотолгоонд суурилна.
- Мэргэшсэн өндөр чадавхитай багаар ажиллан, шилдэг үйлчилгээг хүргэнэ.
- Удирдлага, хамт олны манлайлал, эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, хариуцлагыг эрхэмлэнэ.

6.2. СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ, ЗОРИЛГО, ЗОРИЛТ

СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ 1. НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

Стратегийн зорилго 1. Үйлчлүүлэгчдэд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүргэх

Стратегийн зорилт 1.1.1. Үйлчлүүлэгчдэд арьс харшлын өвчнөөс сэргийлэх эрүүл мэндийн боловсрол олгох, мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийх

Стратегийн зорилт 1.1.2 Арьс харшлын өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээний үр дүнг сайжруулах

СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ 2. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

Стратегийн зорилго 2.1. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний аюулгүй байдал, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх

Стратегийн зорилт 2.1.1. Арьс харшил, эмчилгээний гоо заслын тусламж, үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх

Стратегийн зорилт 2.1.2 Хүлээн авах, яаралтай тусламж, үйлчилгээний зохион байгуулалт, бүтэц, тусламж, үйлчилгээг сайжруулах

Стратегийн зорилт 2.1.3. Чанарын удирдлагын тогтолцоо, арга хэрэгслийг сайжруулан, тасралтгүй байдлыг хангах

Стратегийн зорилт 2.1.4. Арьсны өвчний сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, сувилгаа, асаргааны үр дүнг дээшлүүлэх

Стратегийн зорилт 2.1.5. Эмнэлгийн халдвар, хамгаалал, ариутгалын аюулгүй байдлыг хангах

Стратегийн зорилт 2.1.6. Аюулгүй, эрсдэлгүй тусламж, үйлчилгээг үзүүлэх

Стратегийн зорилт 2.1.7. Үйлчлүүлэгчид, ажилчдын аюулгүй байдлыг хангаж, дэмжлэгт орчныг бүрдүүлэх

СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ 3. ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛ

Стратегийн зорилго 3.1. Тасралтгүй суралцагч байгууллага байж, зөв хандлагад суурилсан хүний нөөцийг хөгжүүлэх

Стратегийн зорилт 3. 1.1. Арьс харшил, эмчилгээний гоо заслын чиглэлээр чадварлаг мэргэшсэн хүний нөөцөөр хангах

Стратегийн зорилт: 3.2.1. Хүний нөөцийн байршил, хангамжийг оновчтой болгож, бие даасан байдлыг хангах

Стратегийн зорилт: 3.1.3. Эрдэм судлал, судалгаа-шинжилгээг хөгжүүлэх

Стратегийн зорилт 3.1.4. Гүйцэтгэлийн удирдлагын оновчтой тогтолцоог нэвтрүүлэх

Стратегийн зорилт 3.1.5. Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцааны соёл, хариуцлагыг дээшлүүлэх

Стратегийн зорилт 3.1.6. Хүний нөөцийн нийгмийн баталгааг сайжруулах

СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ 4. ЭРҮҮЛ МЭНДИЙН САНХҮҮЖИЛТ

Стратегийн зорилго 4.1 Тусламж, үйлчилгээний чанар, гүйцэтгэлтэй нягт уялдуулан, санхүүжилтийн тогтолцоог шинэчлэн, үр ашгийг дээшлүүлэх

Стратегийн зорилт 4.1.1. Эдийн засгийн үр ашиг, өртгийн тооцоолол хийж, санхүүгийн удирдлагыг оновчтой болгох

СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ 5. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТЕХНОЛОГИ

Стратегийн зорилго 5.1. Дэвшилтэт технологийн нэвтрэлтийг хангаж, тусламж, үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулан, хүрээг өргөтгөх

Стратегийн зорилт 5.1.1. Хүн амын арьсны эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд суурилсан дэвшилтэт технологийг нэвтрүүлэх

Стратегийн зорилт 5.1.2. Дэвшилтэт тоног төхөөрөмжөөр хангаж, засвар үйлчилгээний тасралтгүй байдлыг сайжруулах

СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ 6. ЭМ ЗҮЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

Стратегийн зорилго 6.1. Эм зүйн үйлчилгээний хүртээмж, чанар, аюулгүй байдлыг ханган, зохистой хэрэглээг төлөвшүүлэх

Стратегийн зорилт 6.1.1 Клиникийн эм зүйн тусламж үйлчилгээг хүртээмжтэй, чанартай хүргэх

Стратегийн зорилт 6.1.2 Арьс харшил, эмчилгээний гоо заслын эм, био бэлдмэлийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх

СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ 7: МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, МЭДЭЭЛЛИЙН УДИРДЛАГА

Стратегийн зорилго 7.1. Мэдээллийн технологийн нэвтрэлтийг хангаж, цахим эмнэлэг болох

Стратегийн зорилт 7.1.1. Цахим технологийг нэвтрүүлэн, цахим эмнэлэг болох

СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ 8. БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖИЛ, УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Стратегийн зорилго 8.1 Байгууллагын хөгжил, удирдлага зохион байгуулалт, ил тод байдлыг хангах

Стратегийн зорилт 8.1.1. Хагас бие даасан засаглалыг хөгжүүлэх

Стратегийн зорилт 8.1.2. Байгууллагын удирдлага, зохион байгуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлэн, ил тод байдлыг хангах

Стратегийн зорилт 8.1.3. Хэрэглэгч төвтэй, сэтгэлд шингэсэн, үйлчилгээ үзүүлэх

Стратегийн зорилт 8.1.4. Төрөлжсөн мэргэшлээр Улсын хэмжээнд лавлагаа тусламж, үйлчилгээ үзүүлэн мэргэжил арга зүйгээр хангаж, арьс харшил, эмчилгээний гоо заслын мэргэжилтэн бэлтгэх

Стратегийн зорилт 8.1.5. Төр хувийн хэвшлийн түншлэлийг нэмэгдүүлэн, гадаад харилцааг хөгжүүлэх

ДОЛОО. ХҮРЭХ ҮР ДҮН

- 7.1. Арьс харшлын өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үйл ажиллагааны үр дүн, чанар, хүртээмж нэмэгдэж, үйлчлүүлэгчдийн эрүүл мэндийн боловсрол сайжирна.
- 7.2. Арьс харшил, эмчилгээний гоо сайхны тусламж, үйлчилгээний аюулгүй байдал, чанар, хүртээмж сайжирч, хэрэглэгчдийн сэтгэл ханамж нэмэгдэнэ.
- 7.3. Чадварлаг, мэргэшсэн хүний нөөцөөр хангагдаж, бүтээмж нэмэгдэж, нийгмийн баталгаа сайжирна.
- 7.4. Байгууллагын төсвийн орлого, зардлын үр ашиг нэмэгдэн, санхүүгийн удирдлага оновчтой болно.

- 7.5. Дэвшилтэт технологи, тоног төхөөрөмж нэвтэрч, хүн амын арьсны эрүүл мэндийн шинэ эрэлт, хэрэгцээ хангагдана.
- 7.6. Эм зүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж сайжран, эмийн зохистой хэрэглээ төлөвшинө.
- 7.7. Шинэ, дэвшилтэт мэдээллийн технологийн нэвтрэлт хангагдан, цахим эмнэлэг болно.
- 7.8. Хагас бие даасан засаглалтай болж, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн сайжирч, нээлттэй, ил тод байдал хангагдана.

НАЙМ. ҮР НӨЛӨӨ

- 8.1. Арьс харшил, эмчилгээний гоо заслын тусламж, үйлчилгээг олон улсын түвшинд үзүүлж, хүн амын арьсны эрүүл мэнд сайжирч, сэтгэл ханамж дээшилнэ.
- 8.2. Хагас бие даасан засаглал хөгжиж, байгууллагын үр дүн, үр ашгийн тогтвортой байдал хангагдана.

ЕС. САНХҮҮЖИЛТ

- 9.1. Стратегийг хэрэгжүүлэх санхүүжилтийг стратегийн чиглэл, үйл ажиллагаа бүрээр тооцоолон, эх үүсвэрийг нарийвчлан тусгана.
- 9.2. Стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүжилт нь дараах эх үүсвэртэй байна.
 - 9.2.1. Улсын төсөв
 - 9.2.2. Гадаадын хандив, тусламж, төсөл хөтөлбөр
 - 9.2.3. Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт
 - 9.2.4. Төр, хувийн хэвшлийн түншлэл
 - 9.2.5. Өөрийн орлого, бусад эх үүсвэр

АРАВ. ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ БА НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ

10.1. Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд явцын үнэлгээг жил бүр, хөндлөнгийн үнэлгээг 2 жилд нэг удаа хийнэ. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх загвар, аргачлал, шалгуур үзүүлэлтийг тусгайлан боловсруулж, шаардагдах зардлыг төсөвт тусган, хэрэгжилтийг хангаж ажиллана. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг Төлөөлөн Удирдах Зөвлөлд тухай бүр танилцуулан, нэмэлт өөрчлөлтийн талаар хэлэлцэн, шийдвэрлэнэ.

10.2. Стратеги төлөвлөгөөнд өөрчлөлт оруулахдаа хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжид үндэслэн, нэмэлт, өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлагатай нь нотлогдсон, улс, салбарын эдийн засаг, төсөв, санхүүгийн нөхцөл байдал өөрчлөгдсөн тохиолдолд нэмэлт өөрчлөлт оруулна.

АРВАН НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Стратегийн чиглэл	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин 2019 он	Зорилтот түвшин 2024 он
Нийгмийн эрүүл мэнд	Урьдчилан сэргийлэх үзлэгээр илэрсэн өвчнийг эмчлэн эрүүлжүүлсэн байдал	Хувиар	8.7%	12%
Эмнэлгийн тусламж, үйлчилгээ	Эмнэлгээс шалтгаалах халдвар	0	0	0
	Хүндэрсэн өвчтөн, Нас баралт	тоогоор	1	0
	Архаг өвчний хяналт, өвчин намжмал үеийн хугацааг утрасгах	Хувиар	0.6%	1%
	Оношийн зөрүү	Хувиар	0.1%	0
	Сорилын тоо	Тоогоор	7546	10000
	Ховор өвчний тохиолдлын илрүүлэлт	Хувиар	3.5%	4.5%
	Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд сэтгэл ханамжтай үнэлгээ өгсөн үйлчлүүлэгчид	хувиар	90%	99%
Хүний нөөцийн хөгжил	Эмч, сувилагчийн харьцаа	тоогоор	1:1.1	1:2
	Шаардлагатай хүний нөөцийн хангалт	хувиар	85%	100%
Эрүүл мэндийн санхүүжилт	Цалин хөлс, үр дүнгийн урамшуулал	Хувиар	90%	100%
	Төсөвт өөрийн орлого, хөрөнгө оруулалт, хандив тусламжийн нэмэгдсэн үзүүлэлт	Хувиар	85%	100%
Эрүүл мэндийн технологи	Шинэ дэвшилтэт технологийн нэвтрэлт	тоогоор	80%	100%
	Оношилгоо, эмчилгээний стандарт, эмнэл зүйн удирдамжийн мөрдөлтийн хангалт	Хувиар	85%	100%
	Дэвшилтэт тоног төхөөрөмжийн хангалт	Хувиар	80%	100%
Эм зүйн тусламж, үйлчилгээ	Эм зүйн тусламж, үйлчилгээний дэвшилтэт технологийн нэвтрэлт	Тоогоор	80%	100%
	Жор бичилтийн стандартын мөрдөлт	Хувиар	95%	100%
Мэдээллийн технологи, мэдээллийн удирдлага	Алсын зайн оношилгоо, эмчилгээ	Хувиар	90%	100%
	Цахим сүлжээнд холбогдсон үзүүлэлт	Хувиар	85%	100%
Эмнэлгийн удирдлага, зохион байгуулалт ил тод байдал	Санхүүгийн бие даасан байдал	Хувиар		90%

АШИГЛАСАН ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧИГ, ХЭВЛЭЛИЙН ЖАГСААЛТ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл, баримтлал-2030

ХУУЛЬ:

- Монгол Улсын хууль “Эрүүл мэндийн тухай”,
- Монгол Улсын хууль “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай”
- Монгол Улсын хууль “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай”
- Монгол Улсын хууль “ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай ”

ТӨРИЙН БОДЛОГО:

- Гурван тулгуурт хөгжлийн бодлого, 2018 он
- Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, 2017 он,
- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хөгжлийн бодлого, 2014 он

СТРАТЕГИ:

- Монгол Улсын Засгийн газар-Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын хамтын ажиллагааны стратеги (2017-2021 он),
- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хөгжлийн бодлогыг 2015 -2019 онд хөгжүүлэх стратеги, 2015 он
- Эрүүл зан үйл төлөвшүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны үндэсний стратеги, 2010 он
- Вируст гепатиттай тэмцэх үндэсний стратеги, 2010 он
- Шинэ болон сэргэж буй халдварт өвчинтэй тэмцэх үндэсний стратеги, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, 2010 он

ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР:

- Элэг бүтэн Монгол үндэсний хөтөлбөр, 2017 он
- Эрүүл мэнд үндэсний хөтөлбөр, 2010 он
- Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, 2017 он
- Осол, гэмтлээс сэргийлэх үндэсний хөтөлбөр, 2018 он
- Эрүүл шүд –Эрүүл хүүхэд үндэсний хөтөлбөр, 2018 он

НОМ, ГАРЫН АВЛАГА:

- Эмнэлгийн бие даасан байдлыг бэхжүүлэх төсөлТА-9037 MON төслөөс гаргасан сургалтын гарын авлагууд, 2017-2018 он
- Байгууллагын хөгжлийн стратеги боловсруулах гарын авлага, Францын Олон Улсын байгууллага, 2016 он
- Эмнэлгийн удирдлага (гарын авлага), ЭМЯ, ЭМХТ, 2011 он
- Эрүүл мэндийн үзүүлэлт, 2014- 2017 он
- Байгууллагын түүхийн ном
- Үйл ажиллагааны тайлан, танилцуулга